

БАТЛАВ:

БОАЖЯ -НЫ ХБОБНУ -ЫН ГАЗРЫН ДАРГА

Ц. УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮДИЭСЭН:
“ЖИНКОРОНА” ХХК -ИЙН
ЗАХИРАЛ



Н.БАТЦЭНГЭЛ

УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 20 -Р ХОРООНЫ НУТАГТ
БАЙРЛАХ НООС, НООЛУУР УГААХ ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НӨГЖИЙН РД:5060869 /

ХЯНАСАН:

БОАЖЯ -НЫ ХБОБНУГ -ЫН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:

“ЖИНКОРОНА” ХХК -ИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

О.Ууганбаяр

УЛААНБААТАР ХОТ, 2024 ОН

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.2 Төслийн хүчин чадал.....	3
1.3 Төслийн технологи.....	3
1.4 Түүхий эд туслах материал.....	3
1.5 Төслийн усан хангамж.....	3
1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр.....	3
1.7 Химийн бодис.....	4
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	5
.....	5
2.1 Физик газарзүй, газрын гадарга.....	5
2.2 Төслийн талбайн хөрс, ургамлан нөмрөг.....	5
2.3 Төслийн талбайн усан орчин.....	5
2.4 Нийгэм эдийн засгийн тодорхойлолт.....	5
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ...	7
3.1 Агаарын чанарт нөлөөлөх нөлөөлөл.....	7
3.2 Хөрс, ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ.....	7
3.3 Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл.....	7
3.4 Нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал.....	8
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
4.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	10
4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
4.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	13
4.3 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	14
4.4 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал.....	15
4.5 БОМТ -г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар.....	16
4.6 Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	16

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	“Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	Хувийн хөрөнгө оруулалттай “Жинкорона” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011028109, Регистрийн дугаар: 5060869
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5-р хороо, 6 –р хороолол, 49-2, 11 тоот. Утас: 94110153
Төслийн байршил :	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт 0.84 га талбайд байрлана.

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг



Эх үүсвэр: Google earth

Зураг 2. Төсөл хэрэгжих үйлдвэрийн байр



1.2 Төслийн хүчин чадал

Ноос угаах үйлдвэр нь боловсруулалт хийгдээгүй түүхий эдийн хэмжээгээр тооцвол хоногт 2.8 тн, жилд 700 тн ноос угаах хүчин чадалтай ажилладаг. Хятад улсад үйлдвэрлэгдсэн автомат ажиллагаа бүхий LB-023-152 маркийн ноос угаах машинтай, ноос хүлээн авах, дамжуулан угаах болон шавхагч, хатаагч машинууд, пресслэгч аппаратаар тоноглогдсон. Дээрх машин, төхөөрөмжүүд нь угсраа дамжлага хэлбэрээр ажиллах бөгөөд бүрэн автоматжсан байна.

1.3 Төслийн технологи

Тус компаний ноолуур боловсруулах үйлдвэр нь шугаман функциональ зохион байгуулалтын бүтэцтэй бөгөөд түүнд түүхий эд /ноолуур/ бэлтгэх ба хүлээн авах, нөөцлөн хадгалах, ангилан ялгаж төрөлжүүлэх, сэгсрэх, угаах, хатаах, самнаж хялгасыг нь ялгах, прессэлж боох зэрэг технологи дараалалтай байна. Үйлдвэрлэлийн технологийн ерөнхий схемийг дараах зургаар харуулав.

Зураг 3. Ноолуурын үйлдвэрийн технологийн схем



Тус үйлдвэр нь ямааны ноолуурыг өнгөөр ангилан ялгах, түүнийг хүлээн авах, сэвсийлгэх, сэгсэрч механик хольцоос нь цэвэрлэх, угаах, хатаах, хялгас ялгаж самнах замаар боловсруулах зэрэг үйл ажиллагааг үйлдвэрлэлийн цехэд явуулахаар төлөвлөсөн байна.

Тус үйлдвэрийн технологийн шийдлийн гол зорилт нь ноолууран түүхий эдийг угааж хялгасыг нь ялгах замаар түүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэн олон улсын стандартын шаардлагад тохирох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаад зах зээлд нийлүүлэх асуудал юм .

1.4 Түүхий эд туслах материал

Тус үйлдвэр нь түүхий эд бэлтгэлийг баруун зүгийн засмал замын дагуу орших, Эмээлтийн орчимд өөрийн ноолуур хүлээн авах түрээсийн газраараа дамжуулан бэлтгүүлж, ноолуурыг өнгө, микроноор /дундаж голч/ нь ялган, ялгавартай үнээр худалдан хүлээж авдаг байна.

1.5 Төслийн усан хангамж

Үйлдвэрийн зориулалттай усыг өөрийн талбайд гаргасан гүний худгаас хангадаг байна. Тус үйлдвэр нь хоногт 179.4 м3 ус хэрэглэдэг байна.

1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр

“Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 –р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Тус үйлдвэр цахилгаан эрчим хүч, дулаан хангамжаа Төвийн эрчим хүчний нэгдсэн шугамд холбогдон хангаж байна.

1.7 Химийн бодис

“Жинкорона” ХХК -ийн ноолуурын үйлдвэрт угаалгын бодисоос өөр химийн бодис ашигладаггүй байна. Тус үйлдвэр нь ноос, ноолуурын угаалгад зориулж Liquid soap, Solid soap зэрэг саванг уусмал хэлбэрээр бэлтгэж хэрэглэдэг байна.

Ноос, ноолуур угаах үйлдвэр нь жилд 100 тн шингэн, хатуу саван хэрэглэж байна.

Технологит ашиглах шингэн болон хатуу саванг “Жинкорона” ХХК нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны № 0002410 тоот тусгай /2023.04.21-2028.04.21/ зөвшөөрлийн дагуу импортлон авч ашиглаж байна.

Мөн цэвэрлэх байгууламжид PAM, PAC гэсэн 2 химийн бодисыг ашиглана. № 0002363 тоот тусгай /2023.01.12-2027.12.31/ дагуу импортлон авч ашиглаж байна.

Полиакриламайд (PAM) - PAM нь өндөр полимержилт, өндөр молекул болон усанд уусдаг полимер юм. Хатуу шингэнийг салгах процесст, лаг зайлуулах үйл явцын голчлон ашигладаг. Хот суурин газрын бохир ус цэвэрлэх, цаас, хүнс боловсруулах, нефть хийн, металлуургийн боловсруулалт, будах, элсэн чихэр, үйлдвэрийн бүх төрлийн бохир ус цэвэрлэхэд ашиглана.

Полиалюминум хлорид (PAC) - Бохир ус цэвэрлэх процесст PAC нь химийн бохирдолтой бохир ус цэвэрлэх зориулагатай болон хаягдал усны өнгө, булцуу, SS. COD. BOD-ийн тодорхой хувийг багасгана. PAC нь шингэн ба нунтаг хэлбэрээр хийгддэг. Хот суурийн газрын бохир ус цэвэрлэх, цаас, хүнс боловсруулах, үйлдвэрийн бүх төрлийн бохир ус цэвэрлэхэд хэрэглэнэ.

Хүснэгт 1. Цэвэрлэх байгууламжид ашиглах бодисын нэр төрөл, хэмжээ

Д/д	Жилд хэрэглэх хэмжээ /кг/	
	PAC	PAM
1	10 000	500

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Физик газарзүй, газрын гадарга

Төслийн талбай нь Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужид, Газарзүйн бүсчлэлээр ойт хээрийн бүсэд тус тус багтаж байна.

Тус үйлдвэр нь төв суурин бүсэд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Төслийн талбай нь хатуу хучилттай.

2.2 Төслийн талбайн хөрс, ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог

Тус үйлдвэр орчны хөрс нь Монгол орны хөрсөн бүрхэвчийн ангиллаар Хангайн био уур амьсгалын их мужийн хагас чийглэг өндөр бүсчлэл бүхий Хэнтийн өмнөт тойрогт багтана.

Эндэх хөрс хүний үйл ажиллагаагаар хөрсний үржил шимт өнгөн хэсэг үгүй болж хуримтлалын давхарга ил гарчээ. Энд ердийн хар хүрэн хөрс тогтворжиж байсан.

Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг

Тус үйлдвэрийн хашаан доторх ургамлан бүрхэвч үндсэндээ байгалийн унаган төрхөө алдсан. Энд дагуурын хээрийн ургамлын болох өвслөг ургамал ленийн ботууль зонхилж дааган сүүл, зуужууны өвс, ерхөг ургахаас гадна нам газрын хялгана, хазаар өвс ургана.

Байгалийн унаган төрхөөрөө байхдаа Хэнтийн хэв шинжид багтах алаг өвс-бутлаг үетэн, бутлаг алаг өвст хээрийн, алаг өвс-улалж-биелэг өвст-үетэн тухайлбал *Stipa krylovii Roshev.*, *Cleistogenes squarrosa (Trin) Keng.*, *Agropyron cristatum (L.) Beauv.*, *Carex duriuscula C.A.M.*, *Allium bidentatum Fisch.*, *Arenaria capillaris.*, *Sibbaldianthe adpressa (Bge). Juz.*, *Oxytropis kossinskyi B. Fedtsch et N. Basil.* зэрэг олон төрөл зүйлийн баялаг ургамлын нөмрөгтэй байжээ.

Харин одоо үйлдвэр орчимд *Poa attenuata.*, *Festuca lenensis.*, *Koeleria cristata.*, *Helictotrichon schellianum.*, *Festuca sibirica.*, *Artemisia commutata.*, *Artemisia sibirica.*, *Stellera chamaejasme.*, *Gypsophila dahirica.*, зэрэг хөрс, байгалийн зохисгүй нөхцөлд ургадаг хог ургамлууд зонхилж байна.

2.3 Төслийн талбайн усан орчин

Төслийн талбай ус зүйн сүлжээний хувьд Туул голын сав газарт багтана. Төслийн талбай нь төв суурин бүс учир ойр орчимд булаг, шанд, гол горхи, гадаргын усан сүлжээ байхгүй.

Улаанбаатар хот нь /Н.Батсүхийн ангиллаар/ Сэлэнгэ мөрний ай сав дахь геологи орчны Туулын мезо төрлийн, вулканогентерриген, терриген формаци зонхилсон, олон жилийн цэвдгийн 2-р бүсэд хамаарагддаг. Хот орчмын нутгийн геологийн тогтоц, чулуулгийн төрөл, тархалт, байршлын онцлогтой уялдан газар доорхи усны 4 уст бүрдэл, 4 уст давхарга, мөн олон жилийн цэвдэг болон шаварлаг хурдасны үеүд дээр байрласан өлгөмөл усны сул усжсан давхаргууд тархсан байна.

Туул голын сав дахь газрын доорхи ус нь дөрөвдөгчийн сэвсгэр хурдас болох аллюви, деллювийн чулуулгаас зонхилон тогтсон элс, элсэнцэр хөрсөнд агуулагдах бөгөөд анхны уст давхрага 5 – 19 метр, хоёр дахь уст давхрага 35 – 120 метрийн гүнд оршино. Энэ үйлдвэрийн орчимд газрын доорх ус 5- 10 м- ийн гүнд оршино.

2.4 Нийгэм эдийн засгийн тодорхойлолт

Тус үйлдвэр Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд тус дүүрэг нь Улаанбаатар хотын хүн ам шигүү суурьшсан хамгийн том дүүргийн нэг юм. Сонгинохайрхан дүүрэг нь Улаанбаатар хотын баруун хэсэгт Сонгинохайрхан уулын бэлд оршдог. Тус дүүрэг нь 1,200.6 км² газар нутагтай, 257550 гаруй хүн ам оршин суудаг. Засаг захиргааны 32 хороонд хуваагддаг. Тус дүүргийн хэмжээнд Ерөнхий боловсролын 24 сургууль, сургуулийн өмнөх боловсролын төрийн 81 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Тус агуулах үйл ажиллагаа явуулж буй 20-р хороо нь 2021 оны 2 сарын байдлаар 7 270 хүн амтай, 150 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг, гэр хороолол, орон сууцны хороолол хослосон аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн бүс юм. Тус хороонд Монгол мах экспо, Нефть бааз, Магнай Трейдийн агуулах, Буян холдинг, Улаанбаатар импекс, Монос фарм, Монос дээд сургууль, Олимд дээд сургууль, Хүнс трейд, төв цэвэрлэх байгууламж, Монгол транс, Зэвсэгт хүчний 013 дугаар анги, Зэвсэгт хүчний 150 дугаар анги, Хан богд кашмир ХХК, Мон фияа ХХК зэрэг аж ахуй нэгжүүд, Энхжин, Босса, ТНТ, Номин агуулах зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хүснэгт 1. Хүн амын тоо

Дүүрэг, хорооны нэр	Хүйс	2015	2016	2017	2018	2019	2020	2021 оны 02 сар	2023 оны 1 сар
СХД	Нийт дун	30722 4	31580 2	32245 8	32115 0	32758 0	33570 3	34027 2	34211 2
	Эр	15117 7	15306 8	15660 1	15836 1	16158 5	16554 2	16784 5	16899 6
	Эм	15604 7	16273 4	16585 7	16278 9	16599 5	17016 1	17242 7	17311 6
20-р хороо	Нийт дун	7130	6863	6643	6639	6912	7156	7270	7454
	Эр	3539	3290	3217	3335	3411	3539	3599	3716
	Эм	3591	3573	3426	3304	3501	3617	3671	3738

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Агаарын чанарт нөлөөлөх нөлөөлөл

“Жинкорона” ХХК -ийн хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт, үнэр, дуу шуугиан нь гол бохирдуулагч эх үүсвэрт хамаарна.

Үйлдвэрийн байрын агааржуулалтын системийн хүчин чадал түүний дотор ангилан ялгах цехийн сараалжин тавцантай ширээний доороос тоос татах системийг төлөвлөж хийж өгсөн, тэнд ажиллагсадад тоосны хушуувчийг тогтмол хэрэглүүлдэг байна. Мөн салхивчийн системээр сорогдон гадагш агаарт хаягдах тоос нь гадаад орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болох тул тоос баригчтай салхивчийн яндангаар тоногдсон байна.

Агаарын физик бохирдол (чимээ, шуугиан)

Ноос боловсруулах үйлдвэрийн хувьд ажлын байрны агаарын бохирдол, үнэр, тоосжилт, чимээ шуугиан нь ажилчдын эрүүл мэндэд нөлөөлнө. Шуугиан ба доргио нь хүрээлж буй орчинд хэлбэлзэх долгион хэлбэрээр тархаж, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Шуугиан ба доргионы тархалтын зүй тогтол нь ижил, байгаль орчин (хүн, амьтан, ургамал, хот, барилга байгууламж)-д үзүүлэх сөрөг нөлөө нь төстэй юм.

Дуу чимээ бүхэн шуугиан биш юм. Зарим дуу чимээ хүнд тааламжтай байхад (тухайлбал хөгжим), зарим нь тааламжгүй тээртэй байдаг. Мөн тухайн хүнд аятай санагдсан дуу чимээ нь нөгөө хүнд тээртэй санагдаж болно. Иймээс хүнд тааламжгүй нөлөөлдөг тэр дуу чимээг шуугиан гэж нэрлэдэг.

Механик системийн тодорхой давтамж бүхий хэлбэлзэх хөдөлгөөнийг доргио буюу чичиргээ гэж нэрлэдэг. Доргио нь газрын хөрс, шал, барилгын эд ангиудаар дамжин хүн, амьтан, ургамал, барилга байгууламж, хөшөө дурсгал зэрэгт нөлөөлөх бөгөөд ихэнх тохиолдолд шуугианы эх үүсвэр болдог.

Ноолуур, ноос боловсруулах үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүд доргио бага үүсгэдэг боловч зарим машин, тоног төхөөрөмжүүд ажиллах үедээ нэлээд чимээ шуугиан гардаг байна.

3.2 Хөрс, ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ

“Жинкорона” ХХК -ийн байрлаж буй газар нь Туул голын хөндий, нам дэнжид хамаарах бөгөөд аллювийн хөрс зонхилж байсан. Тус талбайд барилга байгууламж, зам тээврийн сүлжээ, машин техникийн хөдөлгөөний улмаас хөрс, ургамлан нөмрөг бараг үгүй болж талбайг хатуу хучилттай болгосон.

- Үйлдвэрийн талбайн байгалийн унаган хөрс, ургамал үндсэндээ устаж үгүй болсон, цаашид нэмж элэгдэл эвдрэлд өртөхгүй
- Хатуу хог хаягдлын улмаас хөрс бохирдож болзошгүй
- Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн улмаас талбайн гаднах талбайд шатах тослох материал алдагдах, тоосжилт үүсэх зэрэг нөлөөллүүд байна

3.3 Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл

Тухайн орчин нь үйлдвэрлэл хөгжсөн төв суурин газар учир гадаргын усанд шууд нөлөө үзүүлэхгүй.

Үйлдвэрлэлийн технологийн болон унд ахуйн хэрэглээний усыг гүний худгийн усаар хангадаг. Энэ нь усны нөөцөд сөргөөр нөлөөлнө.

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр нь Туул голын сав газарт байрлах тул дутуу цэвэрлэсэн болон цэвэрлээгүй бохир ус нь Туул голын усыг бохирдуулах нөхцөлтэй. Ноолуурын үйлдвэрээс гарч буй бохир усанд шүлтийн ба хүчлийн нэгдлүүд, химийн бусад бодис, элементүүдийн агуулга байдаг. Дараах нөхцөл байдлаас шалтгаалж, усны нөөцийг бохирдуулах нөхцөлтэй. Үүнд:

- Ахуйн болон үйлдвэрийн бохир усыг зохих норм, шаардлагын хэмжээнд хүртэл цэвэрлээгүй;
- Цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагаа алдагдсан буюу түүний тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл үүсэх, технологийн горим зөрчигдөх;
- Үйлдвэрүүд бохир усаа урьдчилан цэвэрлэхгүйгээр нэгдсэн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх;
- Хуурай хог хаягдлыг ил задгай хаях, байгаль орчны болон ариун цэврийн байгууллагаас тогтоосон цэгт тусгай графикийн дагуу зайлуулахгүй байх;
- Үйлдвэрийн технологийн горим зөрчигдөх;
- Ажиллагсдын хайнга ажиллагаа;
- Хаягдал ус дамжуулах шугам хоолойн гэмтэл;
- Бохир ус цэвэрлэх төв байгууламж руу очих шугам хоолойн гэмтэл зэргээс шалтгаална.

Дээрх тохиолдлуудад үйлдвэрийн урьдчилсан цэвэрлэх байгууламжаас хотын төв цэвэрлэх байгууламжид орох хүртэл ихээр алдагдах ба бохир ус хөрс, ул хөрсөнд шүүрэн нэвчих үйл явцаар хөрс, гадаргын болон гүний ус, ургамлын нөмрөг ихээр бохирдох нөхцөл бүрдэнэ.

Гүний усны түвшин дээшлэх буюу доошлох, газар хөдлөл, олон жилийн цэвдгийн дээд, доод хил өөрчлөгдөх зэрэг тохиолдол нь болзошгүй сөрөг нөлөөлөл үүсэх үндсэн нөхцөл болно.

Үйлдвэрлэлийн зүй бус үйл ажиллагаанаас шалтгаалж тухайн орчны усан орчны чанарт өөрчлөлт орж болзошгүй бөгөөд улмаар ландшафтын өөрчлөлт хувьсалт бий болж, байгалийн экологийн, эрүүл ахуй-эмгэг зүйн орчны хувьд өвөрмөц нөхцөл байдал үүсч болох талтай.

Биологийн ба үнэрийн бохирдлын хавсарсан үйлчлэлээр үүсч болзошгүй бактериогийн голомтот бүс нь халдварт өвчний үүсэл-тархалтын үндсэн голомт болон хувирдаг.

Бохир усыг технологийн болон эрүүл ахуйн шаардлагын дагуу цэвэрлэн халдваргүйжүүлж хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх асуудал нь Монгол Улсын Байгаль Орчны тогтвортой байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах чухал ач холбогдолтой.

3.4 Нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал

“Жинкорона” ХХК нь үйлдвэрлэл явуулах зориулалтын байрын эрүүл ахуйн шаардлагыг хөдөлмөр хамгаалалын гол асуудлуудтай холбон авч үзсэн байна. Үүнд ажиллагсдын эрүүл ахуйд үйлдвэрийн хортой хүчин зүйлүүд нөлөөлхөөс хамгаалах, нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах техник хэрэгсэл, ариун цэврийн системийг хамруулдаг байна. Тус компани нь үйлдвэрийн барилгад дараах шаардлагуудыг тавьсан байна. Үүнд:

- Газрын доорх усны түвшнээс хонгилын шал дээр байрлах
- Барилгын дээвэр нь байгалийн хур тундас тогтхооргүй байх
- Байгалийн гэрэл /нарны туяа/ аль болох зөв талаасаа тусаж байхаар барилгын байрлалыг сонгох
- Байгалийн агааржуулалт чөлөөтэй явагдах нөхцлийг хангасан байх

- Ажиллагсад унд-ахйун усаар хангагдсан байх
- Үйлдвэрийн хашаан дотор төрөл бүрийн зориулалтаар нүх суваг ухахгүй байх
- Хог хаягдалын савыг хүний тооноос хамааруулан 40 хүний дунд нэг хогийн сав байхаар тооцох
- Шөнийн болон бүрхэг үед үйлдвэрийн гадна орчныг гэрэлтүүлэх гэрэлтүүлгийн системтэй байх
- Ажлын байрны нэг хүнд ноогдох талбайг 4 м²-ээс доошгүй байлгах
- Үйлдвэрийн байрын өндөр 3.2 м-ээс багагүй байх

Үйлдвэрийн байрын зохиомол бичил уур амьсгалын нөхцөл, чимээ шуугиан, чийглэг, тоосжилт, нүдний нарийн хараа шаардсан зогсоо ажлын онцлог нөхцөл зэрэг нь ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг болох нь манай оронд ажиллаж байгаа ижил тастэй үйлдвэрүүдийн үйл ажиллагаа, тэнд явуулсан мэргэжлийн хяналтын байгууллагуудын хэмжилт судалгаанаас харагдаж байгаа билээ. Тухайлбал ангилан ялгах, хялгас ялгах машиндээр ажиллагсад бруцеллез, бусад цехийн машин тоног төхөөрөмж дээр нүдний хараа нарийн шаардах зогсоо байдалд ажиллагсад харааны болон шээс бэлгийн замын, хөлийн судас бүдүүрэх өвчлөлд илүү өртөмтгий байдаг байна.

Иймээс үйлдвэрийн ажлын байрын гэрэлтүүлэг, температур, чимээ шуугиан, тоосжилт зэрэг бичил орчны үзүүлэлтүүд стандарт нормын хэмжээнээс өөр байх нөхцөлд ажиллагсдын эрүүл мэндэд шууд ба шууд бус байдлаар сөрөг нөлөө үзүүлнэ.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хүн, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөгүй ажиллах, байгалийн баялгийг зохистой ашиглах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг хамгаалах нь бидний зорилго юм.

“Жинкорона” ХХК нь 2024 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт 5 275.0 мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь үйл ажиллагааны болон хөдөлмөр хамгаалаллын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ -тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Нийт зардал (2024 он)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	1 540.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Мян.төг	1 000.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	-
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян.төг	1 700.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян.төг	450.0
6	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян.төг	585.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Мян.төг	-
	Дүн		5 275.0

4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин						
Тус компаний үйлдвэрийн ангилан ялгах, хялгас ялгах гэх мэт зарим цех тасгуудын технологийн процессоос гарах тоосжилт, чимээ шуугиан нь үйлдвэрийн ажлын байрны бохирдолтод нөлөөлөөд зогсохгүй орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно.	Хатуу болон шингэн хаягдлаар агаар бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	--*--	--*--	2024 он	- Агаарын тухай хууль, - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) - “Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” MNS 5078: 2001 стандартын шаардлагыг хангасан байх.
	Тоосжилт ихтэй хэсэгт /ангиан ялгах ширээний доор/ агааржуулалтын нэмэлт төхөөрөмж тавих	Төслийн хүрээнд	--*--	--*--	2024 он	
	Агаар дахь хорт боисын хэмжээг ЗДХ-ээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартад заасан хэмжээнд байлгах	Үйлвэрийн хүрээнд	--*--	--*--	2024 он	
	Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэх	Үйлвэрийн хүрээнд	100.0	100.0 x 4 удаа = 400.0	Улиралд 1 удаа	
	Чимээ ихтэй тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, шинэчлэл хийх арга хэмжээ авах	Үйлдвэрийн байранд	--*--	--*--	2024 он	
Дуу чимээ						
Ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Үйлдвэрийн ажиллагсад	5.0	220.0	2024 он	MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм-түвшний хэмжээ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

“Жинкорона” ХХК -ийн Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Усны нөөц, чанар						
<p>Үйлдвэрлэлийн зориулалтаар ус хэрэглэх тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.</p> <p>Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх</p> <p>Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс газрын доорх ус бохирдох, цэвэрлэх байгууламжийн ажиллагааны горимыг алдагдуулах;</p>	<p>Үйлдвэрийн зориулалтаар их хэмжээний ус ашиглах тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Ус хэрэглээний нормыг цех бүр дээр нарийвчлан тогтоох, түүнд үндэслэн ус ашиглалтын гэрээг холбогдох газартай хийх</p>	Төслийн хүрээнд	--*--	--*--	2024 онд	<p>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль</p> <p>- “MNS 6390 : 2013 " Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус” - MNS 6148:2010. Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ,</p>
	<p>Үйлдвэрээс гарч буй бохир усанд шинжилгээ хийлгэж, тэмдэглэл хөтөлж байх</p>	Төслийн хүрээнд	--*--	ОХШХ-т тусгав	Улиралд нэг удаа	
	<p>Бага оврын цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах</p>	Төслийн хүрээнд	--*--	800.0	2024 онд	
	<p>Үйлдвэрийн дотор трап болон гадна худаг, тунгаагуурыг 7 хоногт 2-оос доошгүй удаа цэвэрлэх</p>	Үйлвэрийн хүрээнд	--*--		7 хоногт 2 удаа	
	<p>Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх</p>	Төслийн хүрээнд	--*--	Тоолуурын заалтын дагуу	Тухай бүр	
Хөрс, ургамлан бүрхэвч						
<p>Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс орчны хөрс бохирдох нөхцөлтэй;</p> <p>Технологийн горимыг зөрчих, ажиллагсдын хайнга үйл</p>	<p>Үйлдвэрийн хаягдал бохир ус, угаалгын бодисоор хөрс бохирдож болзошгүй тул хөрсний бохирдлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж байх</p>	Үйлвэрийн хүрээнд	--*--	ОХШХ-т тусгав	Жилд 2 удаа	<p>- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис,</p>
	<p>Үйлдвэрийн гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх</p>	Үйлвэрийн хүрээнд	--*--	120.0	Төсөл хэрэгжих хугацаанд	

“Жинкорона” ХХК -ийн Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх; Үйлдвэр болон ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох.	Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх	Төслийн хүрээнд	--*--	--*--	Сар бүр	элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хогийн савыг ангилан ялгах зориулалттай хогийн сав болгох	Үйлдвэрийн эргэн тойронд	--*--	--*--	2024 онд	
Нийт дүн			1 540.0			

4.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Орчны үзэмжийг сайжруулах, тоосжилтоос сэргийлэх, мод тарих	Цэцгийн мандал байгуулах	Үйлдвэрийн хашаанд	Ширхэг	1	100.0	100.0	2024 онд
2		Зүлэгжүүлсэн талбайд арчилгаа хийх	Үйлдвэрийн хашаанд	Га	0.02	ҮАЗ –д тусгах	ҮАЗ –д тусгах	2024 он
3		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох			--*--	40ш	22.5	900.0
Нийт							1 000.0	

4.3 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Үйлдвэрийн байранд	-	-	Өдөр бүр, тогтмол ажил	- Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1,

“Жинкорона” ХХК -ийн Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх Технологийн хоцрогдол	Ажиллагсадыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйлдвэрийн хэмжээнд	-	-	Жил бүр	- MNS4968:2000. ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага - MNS4995:2000. ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага - MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS5078:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага - MNS5105:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, тавигдах шаардлага - MNS ILO OSH1:2003. ХААЭА-н удирдлын тогтолцооны талаарх удирдамж - MNS ILO OSH0:2003. ХААЭА. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS5002:2000. ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS5390:2004. ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага - MNS ISO13688:2000. ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага
	Үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт	Үйлдвэрийн бүх ажилчдад				
	Үйлдвэрийн ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт	Үйлдвэрийн бүх ажилчдад				
	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Үйлдвэрийг бүхэлд нь	Галын хор 10ш x 50.0 = 500.0 Бусад -700.0	1 200.0	2024 он	

“Жинкорона” ХХК -ийн Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
						- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль - MNS 4996 : 2000. “Ажлын байрны гэрэлтүүлгийн норм” - MNS 5078 : 2001. “Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага”
	Нийт зардал			1 700.0		

4.4 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Жил бүр	45.0 x 10 сар = 450.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг зайлуулж буй цэвэршүүлэх байгууламжтай холбогдож буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Төслийн эхэн үед болон ашиглалтын үед	Үйл ажиллагааны зардалд тусгах	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах		Үйл ажиллагааны зардалд тусгах	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Нийт		450.0	

4.5 БОМТ -г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Хорооны ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	10-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	-
БОАЖЯ -ны ХБОБНУГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-

4.6 Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	Агаарын чанар: / Агаарын бохирдлын шинжилгээ, дуу чимээний хэмжилтийг хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар./	Үйлдвэрийн байранд нэг цэг сонгох	Агаарын найрлага: жилд 1 удаа	80.0	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) NS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм,
2	Усны хяналт шинжилгээ:	Бохир усанд	Жилд 1 удаа.	45.0	MNS 0900 : 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Хөрсний ерөнхий болон хүнд металын шинжилгээ	Үйлдвэрийн гадна талбайд 1 цэг сонгох	Жилд 1 удаа.	Нийт 1 цэгт х 2 дээж х 1 удаа х /30.0 + 30.0/ = 60.0 /Хөрсний химийн шинжилгээ 1дээж-30.0₮, хүнд металлын шинжилгээ 1дээж – 30.0₮/	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4	Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарсан усанд тогтмол шинжилгээ хийх	Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарсан ус	Улиралд 1 удаа	60.0 x 4= 240.000	

“Жинкорона” ХХК -ийн Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
5	Цэвэрлэх байгууламжаас гарах лагт шинжилгээ хийх	Цэвэрлэх байгууламжаас гарах лаг	Улиралд 1 удаа	40.0 x 4 =160.000	
Нийт зардлын дүн				585.0	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жилд **5 275.0 мян.төгрөгийг** төлөвлөж өглөө.

НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	
Дүгнэлт ○ Шийдвэрийн төсөл ○ Ололт, амжилттай тал ○ Дутагдалтай сул тал ○ Шаардлага	

ХОЁР. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	“Жинкорона” ХХК
	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011028109
	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа	Ноос, ноолуур угаах, самнах, анхан шатны боловсруулах үйлдвэрлэл
	ААН-ийн хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5-р хороо, 6 –р хороолол, 49-2, 11 тоот.
	Захирлын нэр, утас	Н. Батцэнгэл
	Мэргэжилтний нэр утас	О.Ууганбаяр 99904437
1.2	Төслийн нэр	“Ноос, ноолуур угаах үйлдвэр”
	Төслийн байршил	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт 0.84 га талбайд байрлана.
	Төслийн ангилал	Ноос, ноолуур угаах, анхан шатны боловсруулах үйлдвэрлэл
	Төсөл эхэлсэн он сар	2007 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.
	Төсөл хэрэгжих хугацаа	5 жил
	ТЭЗҮ болон төсөл батлагдсан эсэх	Төсөлтэй.
	Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ	2023 он 1035 тн ноос ноолуур боловсруулсан.

**ГУРАВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,
ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
2.1	Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	Шаардлагагүй.
	Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	5 жил 8435 м ²
	Тусгай зөвшөөрлийн төрөл	-
	Химийн бодисын хадгалах ажлын байрны дүгнэлт	Мэргэжлийн хяналтын газар 02-04-373/199 2017.03.23
	Галын дүгнэлтийн огноо, дугаар	2104856 2022-03-16-аас 2024-03-16 хүртэл
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	13/4435 ЕҮД 2022 -08-12 “Хос санаа” ХХК
	БОНБНҮ нэлгээний огноо баталсан хуулийн этгээд	БОАЖЯамаар баталгаажуулсан 2023 он Г.Энхмөнх “Хос санаа” ХХК
	Ус ашиглах гэрээний огноо	Ус ашиглах гэрээг тогтмол хийж ирсэн Нийслэлийн Байгаль орчны газар “Ус ашиглах гэрээ” 2022/57
	Газар ашиглалтын гэрээний огноо хуулийн этгээд	2019 оны 08 -р сарын 29 -ний өдөр Дүүргийн Засаг даргын захирамж А/298 тоот ААН Байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 000009585
	Тухайн жилд баримтлаж ажиллах стандартын дугаар	MNS 5563 - 2005 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага MNS 6390-2013 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус MNS 4251 - 2008 Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал, Сэв хялгас, богино ноолуур. Техникийн шаардлага. MNS 0215 - 2007 Ноос, ноолуур. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх. Техникийн шаардлага

**ДӨРӨВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
3.1	Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ	Химийн бодис ашиглахгүй, Шингэн саван – 180 тн Хатуу саван – 20 тн Полиакриламид (РАМ)- 10тн Полиалюминум хлорид(РАК)-50 тн
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
3.2	Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	-
	Тэсрэх дэлбэрэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	-
3.3	Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж - Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ - Аюултай хог хаягдал	“Цэцүүх трейд” ХХК -тай байгуулсан гэрээний дагуу зайлуулж байна.
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай жилийн арга хэмжээний төсөв	450.0

**ТАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН
ЖИЛИЙН ТӨСӨВ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана /мян.төг/
5.1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	5 275.0
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 540.0
	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1 000.0
	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
	Осол, эрсдэлийн болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1 700.0
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	450.0
	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	585.0
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-

ЗУРГАА. МЕТА МЭДЭЭЛЭЛ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл		
6.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	-		
	Төслийн байршил	Д/д	В	L
		1	47 54 05.81	106 46 19.26
		2	47 54 08.33	106 46 19.00
		3	47 54 08.53	106 46 24.85
		4	47 54 08.69	106 46 24.84
		5	47 54 08.77	106 46 26.74
		6	47 54 08.43	106 46 26.78
		7	47 54 08.39	106 46 26.42
		8	47 54 07.56	106 46 26.65
		9	47 54 06.83	106 46 21.57
10	47 54 05.93	106 46 21.84		
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	<p>Агаарын шинжилгээ 47° 54' 6.85"N 106° 46' 20.51"E</p> <p>Хөрсний дээж 47° 54' 5.90"N 106° 46' 19.39"E</p> <p>Усны дээж Худаг-1 47° 54' 10.06"N 106° 46' 16.60"E</p> <p>Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарсан усанд тогтмол шинжилгээ хийх 47° 54' 5.90"N 106° 46' 17.29"E</p> <p>Цэвэрлэх байгууламжаас гарах лагт шинжилгээ хийх 47° 54' 7.90"N 106° 46' 18.63"E</p>		

**ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛЛИЙН ДҮН**

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Эвдэх • Доройтуулах 	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Нөөцийг бууруулах 	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
Амьтан ургамалд үзүүлэх нөлөөлөл <ul style="list-style-type: none"> • амьдрах орчинг хуваах • амьдрах орчинг доройтуулах • амьдрах орчинг хомсдуулах • нөөцийг бууруулах 	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
Агаарт үзүүлэх нөлөөлөл <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Тоос 	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
Түүх соёлын дурсгалт эд зүйлс <ul style="list-style-type: none"> • Хамгаалах • Нүүлгэн шилжүүлэх 	-	-	-	-	

НАЙМ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	Тоо	Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Дүгнэлт
7.1 Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	19	тийм	тийм	
7.2 Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	20	тийм	тийм	
7.3 Төслийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	2	тийм	тийм	

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хяналт шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж	Төсөв, мян.төг
Хөрс	1	Хөрс-1 47° 54' 5.90"N 106° 46' 19.39"E	Жилд 1 удаа	60.0
Ус	1	Худаг-1 47° 54' 10.06"N 106° 46' 16.60"E	Жилд 1 удаа	45.0
Агаар	1	Агаар -1 47° 54' 6.85"N 106° 46' 20.51"E	Жилд 1 удаа	80.0
Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарсан усанд тогтмол шинжилгээ хийх	4	47° 54' 5.90"N 106° 46' 17.29"E	Улиралд 1 удаа	240.0
Цэвэрлэх байгууламжаас гарах лагт шинжилгээ хийх	4	47° 54' 7.90"N 106° 46' 18.63"E	Улиралд 1 удаа	160.0

МЭДЭЭЛЭЛ ГАРГАСАН :

“ЖИНКОРОНА” ХХК -ИЙН
ЗАХИРАЛ

Н.БАТЦЭНГЭЛ